



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2025.02.11 03/642

№ 202502040001
танай -ны № -т

ЖАЙКА-ИЙН МОНГОЛ ДАХЬ
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ДАРГА
МИЯАГИ КЭНСҮКЭ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Юуны өмнө Монгол Улсын "Чингис хаан" нисэх онгоцны буудлын үйлчилгээний чанар, хүртээмжид анхаарал хандуулан нисэх онгоцны буудлын эрэлтийн суурь судалгаа болон өргөтгөл хийх хувилбаруудыг боловсруулан, танилцуулж, хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлье.

Тус судалгааны ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байгаа "Ниппон Коей" компанийн 2024 оны 12 дугаар сард гаргасан судалгааны урьдчилсан тайланд нисэх буудлыг өргөтгөх хувилбар, хэрэгжүүлэх боломжтой хугацаа болон төсвийн саналыг боловсруулж танилцуулсан. Хувилбар тус бүрээр санхүүжилтийг 146,010.0 сая иен, 140,598.0 сая иен, 154,746.0 сая иен болохоор тооцоолсон байна. Анх 70,896.0 сая иенийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн өргөтгөлийн ажил үндсэн төслийн зардлаас хоёр дахин их байна.

Иймд судалгааны тайланд тооцсон өртгийг дахин хянан үзэж, төсвийн тооцооллын талаар илүү нарийвчилсан тодорхой дүгнэлт гаргаж ирүүлнэ гэж найдаж байна.

Бидний ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байгаа ЖАЙКА-ийн хамт олонд талархал илэрхийлье.

Хувийг: Иргэний нисэхийн ерөнхий газарт.

000006673